

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД САНАЛ БОЛГОСОН
НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ АЖЛЫН ХЭСГИЙН
ТАЙЛАН**

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам /цаашид “журам” гэх/-ын 12.1, 12.2, 12.3, 12.4-т заасны дагуу Ажлын хэсэг нь олонхын саналаараа Улсын Их Хуралд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийн талаарх тайланг энэхүү загварт нийцүүлэн бичих үүрэгтэй. Журмын 13.1-д заасны дагуу Ажлын хэсгийн тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах тул уг тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хувь хүний нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

1	Нэр дэвшигчийн товч танилцуулга Эцэг/эхийн нэр: Дашзэвэг Ургийн овог: Дархан Нэр: Эрдэнэчулуун Хүйс: Эрэгтэй Төрсөн он: 1962 Төрсөн газар: Улаанбаатар хот, 1 дүгээр төрөх газар Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал <i>Нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний алинд нэр дэвших тухай хүсэлт гаргасан талаар бичнэ.</i> Нэр дэвшигч Д.Эрдэнэчулуун нь Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвших хүсэлт гаргасан.
Сонгон шалгаруулалт, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга Сонгон шалгаруулалтын найман үе шат бүрийг журмын Дөрөв, Тав, Зургаа, Долоо, Найм, Ес, Арав, Арван нэг, Арван хоёрт заасны дагуу хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой, ойлгомжтой бичнэ.	
3	Нэгдүгээр үе шат <i>Журмын 3.1.1-д заасны дагуу “сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i> Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 5 гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус 5 гишүүнийг Монгол Улсын Их Хурлаас нээлттэйгээр нэр дэвшүүлж, сонгон шалгаруулж томилохоор заасны дагуу 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 17 цаг 30 минут хүртэл олон нийтэд нээлттэй зарлаж, холбогдох материалыг хүлээн авахаар Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолыг баталсан. Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалтын зарыг 2021 оны 03

	дугаар сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд нийтэд мэдээлсэн.
4	<p>Хоёрдугаар үе шат <i>Журмын 3.1.2-т заасны дагуу “нэр дэвших тухай хүсэлт гаргах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сонгон шалгаруулалтын бүртгэлийн хугацааг тогтоож, хүсэлт, материалыг 21 хоногийн хугацаанд хүлээн авахаар нийтэд мэдээлсэн бөгөөд тус хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нийт 59 хүн нэрээ дэвшүүлэн, холбогдох материалыг ирүүлснээс 1 хүн нэрээ татаж нийт 58 хүн нэр дэвших хүсэлт гаргасан.</p>
5	<p>Гуравдугаар үе шат <i>Журмын 3.1.3-т заасны дагуу “Ажлын хэсэг байгуулах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 77 дугаар зүйлийн 77.2-т “Ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Улсын Их Хурлын гишүүн ахална.” гэж заасан.</p> <p>Дээрх заалтын дагуу Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 09, 10, 20 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн даргын зөвлөх Д.Батдорж, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монголын Өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч М.Баасанбат, Монголын Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн М.Мөнхбат, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн танхимын багш доктор, профессор О.Мөнхсайхан, “Сихихутуг” их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч Г.Амаржаргалан нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.</p> <p><i>Тайлбар:</i> Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор Сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан. Монголын Хуульчдын холбооны төлөөллийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бөгөөд Монголын Хуульчдын холбооноос Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн М.Мөнхбатын нэрийг ирүүлсэн тул Хууль зүйн байнгын хорооны 09 дүгээр тогтоолд нэмэлт оруулах тухай 10 дугаар тогтоолыг баталсан. Түүнчлэн Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга А.Бямбажаргалын албан үүрэг өөрчлөгдсөн тул Хууль зүйн байнгын хорооны 09 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай 20 дугаар тогтоолоор ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан.</p>
6	<p>Дөрөвдүгээр үе шат <i>Журмын 3.1.4-т заасны дагуу “нэр дэвшигчээр бүртгэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p>

	<p>Ажлын хэсэг 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хуралдаж Монгол Улсын шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль болон Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-д заасан материалын шаардлагыг хангасан гэж үзэн Д.Эрдэнэчулууныг Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчээр бүртгэсэн.</p>
7	<p>Тавдугаар үе шат <i>Журмын 3.1.5-д заасны дагуу “нэр дэвшигчийн баримт бичгийг цахим хуудаст байршуулах, асуулт, санал хүлээн авах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>“Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 8.1-д “нэр дэвшигчээр бүртгэснээс хойш ажлын нэг өдрийн дотор бүртгэсэн нэр дэвшигчдийн нэрс, нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж түгээнэ.” гэж заасны дагуу нэр дэвшигч Д.Эрдэнэчулууны материалыг www.parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан.</p>
8	<p>Зургадугаар үе шат <i>Журмын 3.1.6-д заасны дагуу “нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 10.1-д “Энэ журмын 9.1-д заасны дагуу бүртгэсэн шийдвэр гармагц Ажлын хэсэг нэр дэвшигчийг Ажлын хэсгийн ахлагчаас бусад гишүүн бүрд тохиолдлын журмаар тэнцвэртэй хуваарилж илтгэгч гишүүнийг томилно” гэж заасныг баримтлан 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Ажлын хэсгийн хуралдаанаар нэр дэвшигч Д.Эрдэнэчулууны илтгэгч гишүүнийг сугалаагаар тодруулж, илтгэгч гишүүнийг томилсон.</p> <p>Илтгэгч гишүүн Журмын 10.2-т заасан ажиллагааг явуулж холбогдох мэдээллийг цуглуулсан. Тухайлбал, нэр дэвшигчийн талаарх баримт материалд дүн шинжилгээ хийх, нэмэлт материал гаргуулан авах, сөрөг мэдээллийн талаар холбогдох талуудаас тайлбар авах, нэр дэвшигчийн талаар мэдээлэл өгч чадах 11 хүнтэй ярилцлага хийсэн.</p>
9	<p>Долдугаар үе шат <i>Журмын 3.1.7-д заасны дагуу “Ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 11.1-д “Энэ журмын 10.7-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигч нь холбогдох шаардлагыг хангасан</p>

	<p>эсэхийг тодруулах зорилгоор Ажлын хэсэг нэр дэвшигч тус бүртэй ярилцлага зохион байгуулна.” гэж, 11.2-д “Ажлын хэсэг зургаагаас доошгүй тооны гишүүний ирцтэйгээр ярилцлага хийх бөгөөд Ажлын хэсгийн ахлагч даргална.” гэж заасан.</p> <p>Ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 8, 9, 10-ны өдрүүдэд ажлын хэсгийн ярилцлагыг зохион байгуулсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд 29 хүн нэр дэвшсэнээс 3 хүн нэрээ татсан бол 1 хүний төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн, 1 хүн ярилцлагад ороогүй тул бүртгэлээс хасаж нийт 24 хүнтэй ярилцлага зохион байгуулсан. Шүүхийн сахилгын хороонд 24 хүн нэр дэвшсэнээс 1 хүн нэрээ татсан тул 23 хүнтэй ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулсан.</p>
<p>10</p>	<p>Наймдугаар үе шат <i>Журмын 3.1.8-д заасны дагуу “нэр дэвшигчийг Улсын Их хуралд санал болгох” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</i></p> <p>“Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 12.1-д “Энэ журмын 11.6-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын дөрвөн өдрийн дотор Ажлын хэсэг дараах журмаар хуралдаж Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.” гэж, мөн журмын 12.6-д “Энэ журмын 12.1-д заасан хуралдаанаас хойш ажлын гурван өдрийн дотор энэ журамд заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлнэ.” гэж заасны дагуу саналаа Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх зохицуулалттай.</p> <p>Ажлын хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4.5- “энэ хуулийн 77.4.4-т заасан санал хураалтын дүнгээр Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хоёр хүртэл хүний хамт нэр дэвшүүлж, Байнгын хороонд тайлангийн хамт ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх.” гэж заасан. Ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, илтгэгч гишүүн бүр өөрсдийн судалсан нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайланг танилцуулж, ажлын хэсгийн бусад гишүүн саналаа хэлж, асуулт асууж хэлэлцсэн. Үүний дараагаар санал хураалтыг нууцаар явуулахад таван нэр дэвшигч Ажлын хэсгийн гишүүдийн олонхын саналыг авсан. Өөрөөр хэлбэл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Ц.Давхарбаяр 11 санал, Д.Ариунтуяа 7 санал, Д.Мягмарцэрэн 7 санал, Д.Эрдэнэчулуун 7 санал, Х.Хашбаатар 6 санал тус тус авсан.</p>
<p>11</p>	<p>Сонгон шалгаруулалтын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>Ажлын хэсэг журмын 7.1-д заасан бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлсэн бэ, мөн журмын 12.4.1-д заасны дагуу сонгон шалгаруулалт нь Шүүхийн тухай хууль болон энэ журмын дагуу явагдсан тухай нэгтгэн дүгнэж бичнэ.</i></p> <p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын Дөрөв, Тав, Зургаа, Долоо, Найм, Ес, Арав, Арван нэг, Арван хоёрт заасны дагуу сонгон шалгаруулалтын найман үе шат тус бүрийг зохион байгуулсан.</p>
<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хангасан тухай үнэлгээ Нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт, нэр дэвшигчийн хэвлүүлсэн бүтээл, олон нийтэд өгсөн мэдээлэл, олон нийтээс ирүүлсэн асуулт, санал, нэр</p>	

<p>дэвшигчийн талаар бусад хүмүүстэй хийсэн ярилцлага, илтгэгч гишүүний ганцаарчлан хийсэн ярилцлага, Ажлын хэсгийн ярилцлага, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан, нэр дэвшигчээс болон бусад этгээдээс гаргуулан авах зэргээр цуглуулсан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтад тулгуурлан нэр дэвшигчид тавих шаардлагыг яагаад хамгийн сайн хангасан гэж үнэлж дүгнэсэн тухайгаа журмын 12.4.3-т заасны дагуу ойлгомжтой, тодорхой бичнэ.</p>	
12	<p>Боловсрол <i>Төгссөн их, дээд сургууль, коллеж, боловсролын зэрэг, төгссөн оноор нь хамгийн сүүлийнхээс нь эхлэн дараалуулж жагсааж, журмын 2.1.2, 2.2.2-т заасан шаардлагыг хангаж байгаа нь ямар мэдээлэл, нотлох баримтаар тогтоогдсон талаар бичнэ.</i></p> <p>Нэр дэвшигч Д.Эрдэнэчулуун нь дараах байдлаар хууль зүйн бакалавр, магистрын зэрэг хамгаалсан байх бөгөөд эдгээрийг нотлох баримтыг нягтлан шалгасан:</p> <ul style="list-style-type: none"> -2008 онд ОХУ-ын Эрхүү хотын Улсын Их сургуульд хууль зүйн магистр хамгаалсан. (№ВО2454) -1984-1990 онд ОХУ-ын /хуучнаар ЗСБНХУ/ Эрхүү хотын Улсын Их сургуульд эрх зүйч мэргэжлээр төгссөн. (УВ №315330), -1970-1980 онд Нийслэлийн 14 дүгээр сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн.
13	<p>Эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан тухай <i>Журмын 2.1.2, 2.2.2-т заасны дагуу эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</i></p> <p>Нэр дэвшигч Д.Эрдэнэчулуун нь дор дурдсан хугацаанд дараах ажлыг эрхэлжээ:</p> <ul style="list-style-type: none"> – 2019 оноос Монголын Олон Улсын арбитрад арбитраар ажиллаж байгаа; – 2016-2019 оны 10 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн; – 2013-2016 оны 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн; – 2002-2013 оны 03 дугаар сар хүртэл Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга; – 2000-2002 оны 09 дүгээр сар хүртэл Улсын Дээд шүүхийн Тамгын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, дарга; - 1998-2000 оны 10 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн; - 1997-1998 онд Гадаад худалдааны арбитрад арбитрад; - 1994-1997 онд Нийслэлийн нотариатын газрын дарга; - 1990-1994 онд Улсын нотариатын конторт Улсын нотариатч, конторын дарга. <p>Түүний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдал (№402954, №0388099, №771851, 2021.03.24-ний өдрийн тодорхойлолт), ажлын байрны тодорхойлолт (Монгол Улсын Олон Улсын арбитрад 2021.03.25 өдрийн 4/153 дугаар тодорхойлолт), ажилд томилж, чөлөөлсөн тушаал, шийдвэр (8 хуудас) зэргээс эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан гэж дүгнэсэн.</p>
14	<p>Хууль зүйн өндөр мэргэжилтэй: хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай тухай <i>Нэр дэвшигч нь журмын 2.1.1, 2.2.1-д заасан шаардлагын хүрээнд “хууль</i></p>

зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай” гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.

Нэр дэвшигч Д.Эрдэнэчулууныг дараах үндэслэлээр “хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай байх” шаардлагыг хангаж байна гэж дүгнэж байна. Үүнд:

Нэр дэвшигч Д.Эрдэнэчулуун нь Шүүхийн сахилгын хорооны гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ Нэр дэвших тухай хүсэлт (2021.03.30)-ийнхээ 3-7 дугаар хуудаст бичжээ. Тэрээр “Шүүгчийн сахилга, хариуцлага, ёс зүйн талаар олон улсын болон үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн сургалт зохион байгуулах, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн талаарх мэдээллийг ил тод болгох, шүүгчийн мэргэжлийн болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хороо ажиллаж болох эсэхийг турших, шүүгчийн сахилга, хариуцлага, тэдгээрт холбогдох хууль тогтоомж, дүрмийн зохицуулалтыг боловсронгуй болгох, шүүгчийн ёс зүй, сахилгын зөрчилд хүлээлгэх хариуцлага, түүний процедурыг нээлттэй болгох, сахилгын зөрчилд хүлээлгэх хариуцлага тохирсон байхад анхаарах, Сахилгын хорооны албаны ажилтны ёс зүйн дүрмийг боловсруулах, шүүгчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, тайлагнах асуудлыг шүүхийн сахилгын хороо хариуцах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх...”, зэрэгт анхаарч ажиллах талаараа дурджээ.

Нэр дэвшигч Д.Эрдэнэчулуун нь Нэр дэвших тухай хүсэлт (2021.03.30)-ийнхээ 7-10 дугаар хуудаст өөрийн хууль зүйн өндөр мэргэшилтэйг харуулах хамгийн чухал 6 мэргэжлийн үйл ажиллагааг жагсаан бичсэн байна. Дараах баримтаас Д.Эрдэнэчулууныг Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллахад шаардлагатай хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай гэж дүгнэсэн.

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын алба, Улсын Дээд Шүүхийн Тамгын газрын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, нотариат, арбитрч зэрэг хууль зүйн өндөр мэдлэг, чадвар шаардсан ажлыг тасралтгүй 30 гаруй жил эрхэлж, шүүхийн шинэчлэл, талуудын хөндөгдсөн эрх ашгийг хамгаалах, сэргээх мэргэжлийн үйл ажиллагаа явуулж ирсэн байдал.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр 2013 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 6 жил ажилласан байна. Ажиллах хугацаандаа шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хуульчдаас шүүгчийг шилж сонгох ажлыг хэрэгжүүлж энэ хүрээнд тэдгээрт хамаарах асуудлын талаар дүрэм журмыг дангаар болон хамтран боловсруулах, батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах ажлыг эрхэлсэн. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал харьцангуй утгаараа хангагдсан. түүнчлэн шүүн таслах ажиллагааны хэвийн, тасралтгүй, аюулгүй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шүүхийн захиргааны байгууллагуудын мэргэжлийн удирдлагаар хангах хамтын удирдлагын шуурхай байдлыг хангуулж, иргэд, хэргийн оролцогчдын зөрчигдсэн эрхээ шүүхийн журмаар нөхөн сэргээлгэх захиргаа-үйлчилгээний орчныг зохих хэмжээнд бүрдүүлжээ.

3.Шүүхийн захиргааны үйл ажиллагаа, хуульчдаас шүүгчийг шилж

сонгох, сургалтын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад чиглэгдсэн баримт бичиг боловсруулах ажилд үр дүн гарган ажиллажээ. Тухайлбал, өөрийн харьяалдаг байгууллагын нэрийн өмнөөс бэлтгэсэн эсхүл бэлтгэхэд оролцсон 40 орчим эрх зүйн баримт бичгийн жагсаалтыг нэр дэвших хүсэлтэд ирүүлсэн бөгөөд хамтран ажиллаж байсан болон удирдах ажилтантай хийсэн ярилцлага, нэр дэвшигчийн талаар гаргасан тодорхойлолт зэргээр нягтлан шалгахад түүний оролцоо бодитой байна.

4.Шүүхийн захиргаа, менежментийн чиглэлээр бусадтай хамтран туурвисан, хянан тохиолдуулсан гарын авлага 1, Монгол Улсын дээд шүүхийн 2004-2019 оны хоорондох 16 удаагийн тайлан, эмхэтгэл боловсруулах, нийтийн хүртээл болгох ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан нь шүүхийн ил тод байдал, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ.

5.Улсын Дээд шүүхийн Үндсэн хуулиас бусад хуулийн албан ёсны тайлбарын төслийг боловсруулахад судалгаа, мэдээлэл, арга зүй, техникийн туслалцаа үзүүлэх замаар уг тайлбарыг боловсруулах, батлах ажиллагаанд дэмжлэг үзүүлэн оролцож байсан туршлагатай.

6.Шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах, шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих, шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч бүртгэх ажлыг зохион байгуулах, шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах, хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх зэрэг ажлуудыг зохион байгуулах, мэргэжлийн шууд удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж нэг талаас иргэд, хэргийн оролцогчдын зөрчигдсэн эрхээ шүүхийн журмаар нөхөн сэргээлгэх эрхийн хэрэгжилтийг зохион байгуулалтын хувьд дэмжлэг үзүүлж, нөгөө талаар шүүн таслах ажиллагааны хэвийн, тасралтгүй, аюулгүй нөхцөлийг хангуулан ажиллажээ.

7.Нэр дэвшигчийн талаарх болон түүнтэй хийсэн ярилцлагууд, түүний талаар гаргасан тодорхойлолт, саналаас харахад нэр дэвшигч Д.Эрдэнэчулууныг хууль зүйн өндөр мэргэшилтэй, шүүхийн захиргааны тусгайлан бэлтгэгдсэн, төрийн албаны мэргэшсэн цөөхөн ажилтнуудын нэг, хууль хэрэглэх өргөн мэдлэгтэй, аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэх “шүүгч”-ийн дадал эзэмшсэн гэж дүгнэж байв.

Нэр дэвшигч Д.Эрдэнэчулууны талаар түүний удирдах албан тушаалтан, хамтран ажиллаж байсан болон удирдлагад нь ажиллаж байсан 11 хүнтэй утсаар болон биечлэн уулзаж ярилцлага хийсэн. Эдгээр хүмүүс эрх зүйч мэргэжлээр олон жил тасралтгүй хууль, шүүхийн байгууллагад ажиллаж шүүгчийг шилж сонгох ажлыг чадварлагаар хийж ирсэн хууль хэрэглээний өндөр мэдлэг, туршлагатай, шүүгчийг шилж, сонгох шинэ арга барилаар ажиллаж, шүүгчид тавьдаг мэргэжлийн болон ёс зүйн дэлхий нийтийн стандарт, шаардлагыг сайн мэддэг нэр дэвшигч, шүүхийн байгууллага, шүүгчийн ажил, амьдралын онцлогийг мэддэг, удирдан зохион байгуулах чадвар сайтай, насны хувьд тохиромжтой удирдах ажилтан гэж нийтлэг байдлаар тодорхойлж байв.

15 Хууль зүйн өндөр мэргэшилтэй: мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлага хангасан тухай

	<p><i>Нэр дэвшигч нь журмын 2.1.1, 2.2.1-д заасан шаардлагын хүрээнд “бусдын нөлөөнд автахгүй, хараат бусаар ажиллах, зарчимч, шударга зан төлөвтэй, мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлагыг хангасан” гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</i></p> <p>Нэр дэвшигч Д.Эрдэнэчулуун нь бусдын нөлөөнд автахгүй, хараат бусаар ажиллах, зарчимч, шударга зан төлөвтэй, мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлагыг хангасан гэж дүгнэж байна. Үүний үндэслэлийг товч танилцуулъя.</p> <ul style="list-style-type: none"> - Нэр дэвшигчийн талаар гаргасан тодорхойлолтуудад “зан төрхийн хувьд шударга, зарчимч, аливаа асуудалд нухацтай ханддаг, хэлсэн үг, гаргасан шийдвэртээ эзэн болдог, хэний ч нөлөөнд автахгүй, хууль бус, ёс зүйгүй үйлдлийг тэвчдэггүй, хүн болгонд найр тавьдаггүй, бас зоримог, шийдэмгий зантай, шийдвэр гаргаж сурсан хүн” гэж дүгнэжээ. - Нэр дэвшигчийн талаар мэдээлэл өгч чадах 11 хүнтэй ярилцлага хийхэд “...Сахилга ёс зүй, хариуцлагын хувьд бусдад маш өндөр шаардлага тавьдаг, өөрөө үлгэр дууриалал болсон ноён нуруутай, аливаа асуудлыг эв зүйгээр, олон талаас нь харж шийдвэрлэхийг эрмэлздэг. Зарим тохиолдолд хэт дундыг барьсан шинжтэй гэж дүгнэж байв. - Нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага, иргэдээс ирүүлсэн сөрөг мэдээлэлд тэрээр үнэнчээр, хууль зүйн үндэслэлтэй тайлбар өгч байв. Тухайлбал, “ ...Миний эхнэр Х.Э нь Улсын Дээд шүүхэд шүүгчээр ажилладаг нь үнэн. Бид ажил хэргийн асуудлаар хоорондоо ярилцдаггүй, зохимжгүй гэж үздэг, бид бие биедээ нөлөөлж байсан тохиолдол байхгүй..., хэрэв Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаж байхад миний эхнэртэй холбоотой асуудал хөндөгдвөл Шүүхийн тухай хуулийн 98 дугаар зүйлийн 98.3 дахь хэсэгт зааснаар татгалзан гарах үүрэгтэй” гэжээ. - Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байхад шүүгч нартай холбоотой хэд хэдэн анхаарал татсан асуудал гарч байсан. Тухайлбал, нэр бүхий 12 шүүгчийг томилоогүй, шүүгч нарын санал хүсэлтийг харгалзахгүйгээр орон нутагт томилж байсан зэрэг асуудал. Энэ бүх асуудалд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний хувьд байр суурь, үзэл бодлоо илэрхийлж, эрх ашгийг нь хамгаалах ажил хийж байсан талаар ганцаарчилсан болон ажлын хэсгийн ярилцлага дээр дурдаж байв. - Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, ажилд томилогдсон болон чөлөөлөгдсөн шийдвэрээс дүгнэхэд сахилгын шийтгэлээр халагдаж эсхүл огцорч байсан баримт тогтоогдоогүй.
<p>16</p>	<p>Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй тухай <i>Журмын 2.1.3, 2.2.3-т заасны дагуу “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй” байх шаардлагыг хангаж байгааг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i></p> <p>Монгол Улсын иргэний үнэмлэхэд “1962 төрсөн” гэж тэмдэглэгдсэн байх бөгөөд нэр дэвшигч нь 59 настай тул “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх” шаардлагыг хангаж байна.</p>
<p>17</p>	<p>Монгол Улсын иргэн мөн тухай <i>Журмын 2.1, 2.2-т заасны дагуу “Монгол Улсын иргэн” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан</i></p>

	<i>дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>
	Монгол Улсын иргэнийг гэрчлэх Монгол Улсын иргэний үнэмлэхийг үндэслэн “Монгол Улсын иргэн” байх шаардлагыг хангаж байна гэж дүгнэлээ.
18	Сүүлийн таван жилд улс төрийн болон намын удирдах албан тушаал хашиж байгаагүй тухай <i>Журмын 2.1.5, 2.2.4-т заасны дагуу “сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах тушаал эрхэлж байгаагүй” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>
	Нэр дэвшигчээс ирүүлсэн баримт бичиг, ярилцлага, цуглуулсан мэдээлэлд үндэслэн “улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах тушаал эрхэлж байгаагүй байх” шаардлагыг хангаж байна гэж дүгнэлээ.
19	Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай <i>Журмын 2.1.6, 2.2.10-т заасны дагуу “эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж байгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>
	Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болдоос 2021.04.29-ний 01/397 тоот албан бичгээр УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогтод ирүүлсэн лавлагаагаар Д.Эрдэнэчулуун нь эрүүгийн хариуцлага хүлээж байсан тухай мэдээлэл бүртгэгдээгүй байна.
20	Сахилгын шийтгэлээр халагдаж, эсхүл огцорч байсан тухай <i>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан эсэхийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>
	Нэр дэвшигчийн талаар гаргасан тодорхойлолт, ярилцлагын мэдээлэл, нэр дэвшигчээс ирүүлсэн баримт бичигт үндэслэн нэр дэвшигч сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байгаагүй байна гэж дүгнэлээ.
21	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй тухай <i>Журмын 2.2.6, 2.3-т заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй буюу ажиллаж байгаагүй, Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>
	Нэр дэвшигч Д.Эрдэнэчулуун нь одоогоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллахгүй байгаа нь ирүүлсэн баримт бичиг, ажлаас чөлөөлсөн тушаал шийдвэр, ажил байдлын тодорхойлолтоор нотлогдож байх тул энэ шаардлагыг хангаж байна гэж үзсэн.
22	Шүүгчээр ажиллаж байгаагүй тухай <i>Журмын 2.1.4, 2.2.4, 2.2.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч сүүлийн таван жил шүүгчээр ажиллаж байгаагүй байх, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч шүүгчээр ажиллаж байгаагүй байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>

	Нэр дэвшигчээс ирүүлсэн нотлох баримт болох ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн шийдвэр, нийгмийн даатгалын дэвтэр, холбогдох хүмүүсийн гаргасан тодорхойлолтыг үндэслэхэд нэр дэвшигч нь шүүгчээр ажиллаж байгаагүй тул “сүүлийн таван жил шүүгчээр ажиллаж байгаагүй байх” шаардлагыг хангаж байна гэж үзсэн.
23	Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй тухай <i>Шүүхийн тухай хуулийн 95.9-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>
	Нэр дэвшигчээс ирүүлсэн нотлох баримт болох ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн шийдвэр, нийгмийн даатгалын дэвтэр, холбогдох хүмүүсийн гаргасан тодорхойлолтыг үндэслэхэд нэр дэвшигч нь “Шүүхийн сахилгын хороо”-ны гишүүнээр ажиллаж байгаагүй тул энэ шаардлагыг хангаж байна гэж үзсэн.
24	Шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллахгүй байгаа тухай <i>Журмын 2.1.7-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>
	Нэр дэвшигчээс ирүүлсэн нотлох баримт болох ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн шийдвэр, нийгмийн даатгалын дэвтэр, холбогдох хүмүүсийн гаргасан тодорхойлолтыг үндэслэхэд тэрээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтнээр 1998-2000 онд, Улсын Дээд шүүхийн Тамгын хэлтэс, газрын даргаар 2000-2013 онд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр 2013-2019 он хүртэл ажиллаж байсан бөгөөд одоогоор шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллаагүй байна. Тиймээс нэр дэвшигчийг “Шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллаагүй байх” шаардлагыг хангаж байна гэж үзсэн.
25	Өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа тухай <i>Журмын 2.2.8-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>
	Нэр дэвшигчээс ирүүлсэн нотлох баримт болох ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн шийдвэр, нийгмийн даатгалын дэвтэр, холбогдох хүмүүсийн гаргасан тодорхойлолтыг үндэслэхэд нэр дэвшигч нь “Өмгөөлөгчөөр ажиллаагүй байх” шаардлагыг хангаж байна гэж үзсэн. Харин Монголын Олон Улсын Арбитрт арбитрчаар 2019 оноос өнөөг хүртэл ажиллаж байгаа тухай тодорхойлолт ирүүлжээ.
26	Прокуророор ажиллахгүй байгаа тухай <i>Журмын 2.2.9-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь прокуророор ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</i>
	Нэр дэвшигчээс ирүүлсэн нотлох баримт болох ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн шийдвэр, нийгмийн даатгалын дэвтэр, холбогдох хүмүүсийн гаргасан тодорхойлолтыг үндэслэхэд нэр дэвшигч нь “Прокуророор ажиллаагүй байх” шаардлагыг хангаж байна гэж үзсэн.

27	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн, эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд санал болгох үндэслэлүүдийг нэгтгэн дүгнэх нь <i>Ажлын хэсэг нь цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэлд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, ёс зүй, зан төлөвийг үнэлж журмын 2.1, 2.2, 2.3-т заасан харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хамгийн сайн хангаж буй гэдгийг нэгтгэн дүгнэн үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.</i></p> <p>Д.Эрдэнэчулуун нь 1990 онд ОХУ-ын Эрхүү хотын Улсын Их сургуульд эрх зүйч мэргэжлээр төгссөнөөс хойш Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, Улсын Дээд шүүхийн Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, нотариат, арбитраар тасралтгүй 30 гаруй жил ажилласан, шүүхийн захиргаа, менежментийн чиглэлээр мэргэшиж, хууль зүйн өндөр мэдлэг, чадвар эзэмшжээ. Тэрээр шүүхийн байгууллагад ажиллах хугацаандаа шүүхийн багц хуулиудыг хэрэгжүүлэх, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хуульчдаас шүүгчийг шилж сонгох ажлыг мэргэжлийн төвшинд хэрэгжүүлж, энэ хүрээнд тэдгээрт хамаарах 40 гаруй дүрэм журмыг дангаар болон хамтран боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах, шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах чиглэлээр олон талын туршлага хуримтлуулсан хуульч юм.</p> <p>Д.Эрдэнэчулуун нь эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан; төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй; сүүлийн таван жил шүүгчээр ажиллаагүй; сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй; Шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллаагүй; эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй; сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байгаагүй нь нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт, нэр дэвшигчийн талаар олон нийтээс ирүүлсэн асуулт, санал, нэр дэвшигчийн талаар бусад хүмүүстэй хийсэн ярилцлага, нэр дэвшигчтэй илтгэгч гишүүний ганцаарчлан хийсэн ярилцлага, Ажлын хэсгийн ярилцлага, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан, нэр дэвшигчээс болон бусад этгээдээс гаргуулан авсан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримт зэргээр тогтоогдсон.</p> <p>Иймд нэр дэвшигч Д.Эрдэнэчулууныг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсэгт заасан Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлагуудыг бүрэн хангаж байна гэж Ажлын хэсэг дүгнэж байна.</p>
-----------	--

Ажлын хэсгийн гишүүд

	Эцэг/эхийн нэр, өөрийн нэр	Гарын үсэг	Огноо
1			
2			
3			
4			

5			
6			
7			
8			
9			
10			
11			

Хавсралт: Тайлан гаргахад тулгуурласан баримт

1. Нэр дэвшигчээс УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан нэр дэвших тухай хүсэлт-8 хуудас;
2. Төрийн албан хаагчийн анкет-4 хуудас;
3. Монгол Улсын иргэний үнэмлэхийн хуулбар -1 хуудас;
4. Бакалаврын дипломын хуулбар (эрх зүйч)-2 хуудас;
5. Хууль зүйн магистрын дипломын хуулбар-1 хуудас;
6. Эрх зүйч мэргэжлээр нийт 31 жил ажилласан тухай Шүүхийн ерөнхий зөвлөлийн тодорхойлолт, 2021.03.25 дугаар 01/285;
7. Ажлын туршлагын тухай Монголын Олон Улсын арбитрын ерөнхий нарийн бичгийн даргын тодорхойлолт, 2021.03.25. дугаар 4/513;
8. Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай төрийн мэдээллийн сангийн лавлагаа, 1 хуудас, 2021.03.24;
9. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч С.Бямбацогтод Цагдаагийн ерөнхий газрын даргаас ирүүлсэн 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 01/397 тоот лавлагаа;
10. Тодорхойлолт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга асан, шинжлэх ухааны доктор, профессор Н.Лүндэндорж, 1 хуудас;
11. Тодорхойлолт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, доктор, дэд профессор Э.Батбаяр, 2 хуудас;
12. Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн асан О.Зандраа, 2021.03.26, 2 хуудас;
13. Улсын Дээд шүүхийн Тамгын хэлтсийн даргын ажилд түр томилсон тухай Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын захирамж, 2000.10.31, дугаар 84;
14. Улсын Дээд шүүхийн Тамгын хэлтсийн даргын ажилд томилох тухай захирамж, 2001.01.02, дугаар 01;
15. Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын ажилд томилох тухай Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол, 2002.09.09, дугаар 35;
16. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 05 дугаар сарын 06-ний өдрийн 63 дугаар зарлиг;

17. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүний дарга, гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 58 дугаар зарлиг;
18. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 59 дүгээр зарлиг;
19. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний албан тушаалаас чөлөөлөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 195 дугаар зарлиг;
20. Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар №402954, 1994.10.12, 11 хуудас;
21. Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар №77185, 3 хуудас;
22. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, 2021.03.24, 5 хуудас;
23. Нэр дэвшигч Д.Эрдэнэчулуунтай ганцаарчлан уулзсан ярилцлагын тэмдэглэл- 3 хуудас;
24. Нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүмүүстэй хийсэн ярилцлагын тэмдэглэл 8 хуудас;
25. Бүтээлийн жагсаалтад хамаарах материал -61 хуудас.

--oOo--